

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 02 сарын 19-ны өдөр

Даланзадгад сум

Дугаар...

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Өмнөговь аймаг/нийслэл/, Даланзадгад сум/дүүрэг/, 6р баг, нутаг дэвсгэрт баригдсан Дунд төвөгшилтэй барилга байгууламж ангиллын, 40 ортой сэргээн засах уламжлалт эмнэлэгийн зориулалттай барилга байгууламжид Өмнөговь аймаг/нийслэл/-н Засаг даргын 2024-12-20-ны өдрийн дугаар шийдвэрээр байгуулагдсан 19 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс 2024-12-23-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний огноо, дугаар: 2023.06.22, зөвшөөрлийн дугаар 2023/38

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ОТ-11/2018

2.3. Захиалагч: Иргэн/Хуулийн этгээдийн нэр: Өмнөговь аймгийн эрүүл мэндийн газар РД-9047751, Хаяг: Өмнөговь аймаг Даланзадгад сум Шинэ суурьшлын бүс 6-р баг, Холбоо барих утас: 99352226, Цахим хаяг: umnugoviemg@gmail.com

2.4. Барилгын ажил гүйцэтгэгч: “Хөх бүрдний Эх” ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011392067, Регистрийн дугаар: 567451, Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: БУ44-81/21, Хаяг: Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Номгон 1-р баг, Хөх бүрдний Эх ХХК-ны байр, Холбоо барих утас: 99118829, Цахим хаяг:

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Байugg

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:

Хуулийн этгээдийн нэр: “ОНЧ ТЭНХЛЭГ” ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011303029, Регистрийн дугаар: 5504643, Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар: ЗТ19-689/19,

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, 12в байр 13 тоот, Холбоо барих утас: 99174540, Цахим хаяг:

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

Хуулийн этгээдийн нэр: : Иргэн/Хуулийн этгээдийн нэр: Өмнөговь аймгийн эрүүл мэндийн газар РД-9047751, Хаяг: Өмнөговь аймаг Даланзадгад сум Шинэ суурьшлын бүс 6-р баг, Холбоо барих утас: 99352226, Цахим хаяг: umnugoviemg@gmail.com



ХОТ БАЙГУУЛАЛТЫН
КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН
САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шинэ****Гурав. Дүгнэлтийн хэсэг**

☐ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

☐ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэхүү Энэ **Дунд төвөгшилтэй барилга байгууламж** ангиллын, **40 ортой сэргээн засах уламжлалт эмнэлэгийн** зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос

ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;



ХОТ БАЙГУУЛАЛТЫН
КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН
САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 4 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 3 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох 32 хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй барилга байгууламж ангиллын, 40 ортой сэргээн засах уламжлалт эмнэлэгийн зориулалттай барилга зориулалттай барилга байгууламжийг ашиглалтанд оруулах дүгнэлт гаргасан:

КОМИССЫН ДАРГА:
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

/Л.ЭРДЭНЭ/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: АИМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗРЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН МЭРТЭЖИЛТЭН

/Н.ТҮВШИНЗАЯА/



ХОТ БАЙГУУЛАЛТЫН
КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН
САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД СУМЫН 6-Р БАГТ БАРИГДСАН 40 ОРТОЙ СЭРГЭЭН ЗАСАХ УЛАМЖЛАЛТ ЭМНЭЛГИЙН БАРИЛГЫГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД ӨГӨХ УЛСЫН КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ.

2024.12.23 өдөр

№

Өмнөговь аймаг Даланзадгад сум

Өмнөговь аймгийн Даланзадгад сумийн 6-р багт баригдсан 40 ортой Сэргээн засах уламжлалт эмнэлгийн барилгыг байнгын ашиглалтад өгөх Улсын комиссын хурал 2024 оны 12 дугаар сарын 02-ны 10 цагт 17 хүний бүрэлдэхүүнтэй хуралдав.

КОМИССИЙН БҮРЭЛДЭХҮҮНД :

1. Комиссийн дарга: Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хяналт шалгалтын хэлтсийн дарга **Л.Эрдэнэ**
2. Комиссийн нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн **Н.Түвшинзаяа**
3. Эрүүл мэндийн газрын дарга **Ц.Жавзандулам**
4. Архивийн тасгийн дарга **Ө.Учрал**
5. Эрүүл ахуй, халдвар хамгаалалын хяналтын улсын ахлах байцаагч **Б.Оюунсүрэн**
6. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн **М.Цэцэгсүрэн**
7. Хот байгуулалын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн **П.Мөнх-Эрдэнэ**
8. Өргөх байгууламжийн хяналтын улсын байцаагч **Ж.Мөнх-Эрдэнэ**
9. Эрүүл мэндийн газрын эдийн засагч **О.Уугантуяа**
10. Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч **Б.Наранцацрал**
11. Өмнөд бүсийн цахилган түгээх сүлжээ ТӨХК-ийн ерөнхий инженер **Т.Гантөмөр**
12. Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн Өмнөговь аймгийн газрын ерөнхий инженер **А. Нарантунгалаг**
13. Даланзадгад дулаан хангамжийн газар, ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер **Р.Цогтбаатар**
14. Гүний ус ХХК-ийн ерөнхий инженер **С.Отгончулуун**
15. Өмнөговь аймгийн Хөгжлийн бэршээлтэй иргэд, байгууллагуудын Ёл холбоо НҮТББ-ын тэргүүн **И.Тунгалаг**
16. “Онч Тэнхлэг” ХХК-ийн ерөнхий инженер **Т.Баттулга**
17. “Хөх бүрдний Эх” ХХК-ийн барилгын инженер **Ж.Отгонцэцэг**

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Захиалагч байгууллага Өмнөговь аймгийн засаг даргын тамгын газрын комисс ажиллуулах тухай хүсэлтийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж байна.

Комиссын дарга ирц бүрдсэнийг онцолж хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулснаар эхлэв.

Барилга байгууламжийн талаар:

“Хөх бүрдний Эх” ХХК-ийн барилгын инженер Ж.Отгонцэцэг: Манайх тухайн барилгыг улс болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар барьсан 2023/06/05-ны өдөр ажлаа эхэлсэн бөгөөд гэрээний хугацаа 2024/12/31-ний өдөр дуусахаар байгаа. Барилга угсралтын ажил дээр Ганчимэг овогтой Аавынхүү инженерээр ажилласан ч ар гэрт нь асуудал гарсны улмаас манай Н.Батбаатар инженер ирсэн байна. Талбайн менежер Гаваасүрэн ажиллаж байна. Барилгын ерөнхий танилцуулгыг инженер Батбаатар хийнэ.

Хөх бүрдний эх ХХК-ийн инженер Батбаатар: Заа сайн байцгаана уу? Сэргээн засах уламжлалт эмнэлгийн барилга нь 40 ортой бөгөөд ерөнхий захиалагч нь ЭМЯ, Өмнөговь аймгийн засаг даргын тамгын газар, захиалагчийн хяналт тавьсан байгууллага барилга хөгжлийн төв, Өмнөговь аймгийн газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, зураг төслийг Онч тэнхлэг ХХК, гүйцэтгэгч байгууллагаар Хөх бүрдний эх ХХК, Нэмүүн инженер ХХКомпаниуд /туслан гүйцэтгэгч/ , Ханбаян констракшн /Туслан гүйцэтгэгч/ тус тус ажилласан. Барилгын ерөнхий төлөвлөгөө 23,908м.кв талбайд барилгын хийцлэл цутгамал бетон карказ бүхий зоритой 4 давхар барилга, 4 метал фасадтай, суурь 33*10, 20*10 харьцаатай ба 1-р давхартаа амбулатори болон захиргааны хэсэг, 2-р давхартаа сэргээн засах эмчилгээний хэсэг, 3-р давхартаа уламжлалт эмчилгээний тасаг, 4-р давхартаа эмийн сан, рестарон, ногоон байгууламж, зоорийн давхартаа эмчилгээний тасагтай болно. Зураг харуулаад тайлбар хийе.

Хуралдаан даргалагч: Заа комиссын гишүүд асуулт байна уу?

Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн М.Цэцэгсүрэн: Манай зүгээс рентгений өрөөтэй больё гэсэн хүсэлт өгсөн энэ яаж шийдэгдсэн бэ?

Хөх бүрдний эх ХХК-ийн инженер Ж.Отгонцэцэг: Энэ удаагын зураг төсөв дээр рентгений өрөө гэж тусдаа өрөө байхгүй байсан. Хэрвээ ашиглагчийн зүгээс санал хүсэлтээ өгөөд, яг аль өрөөгөө рентгений өрөө болгохоо шийдээд зургийн байгууллагатай ярьж зураг төсөл, хөрөнгө мөнгийг шийдсэний дараа манай зүгээс хийхэд татгалзах зүйлгүй. Гэхдээ нэмэлт ажил учраас тендер зарлагдах эсэхийг захиалагч байгууллага шийдвэрлэх байхаа.

Өргөх байгууламжийн хяналтын улсын байцаагч Ж.Мөнх-Эрдэнэ: Усан санд хаалт хамгаалалт, хашилт бий юу? Тэнд хүн живбэл яах вэ? Аюулыг мэдээлэх дохиолох зүйл бий юу?

“Онч Тэнхлэг” ХХК-ийн ерөнхий инженер Т.Баттулга: Энэ усан санд ганцаараа орох боломжгүй, сэргээн засах сувиллын зориулалттай усан сан учраас заавал хөдөлгөөн засалч эмч дасгалжуулагчтай хамт орно.

Хэр хугацаанд усаа шавхаж дуусах вэ?

Хөх бүрдний эх ХХК-ийн инженер Н.Батбаатар: 3-4 цаг, ультра гурвалсан шилтүүртэй.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ: ТӨХК-ийн ерөнхий инженер Т. Гантөмөр Гадна цахилгаан яагаад одоо хүртэл татагдаагүй юм бэ? Үндсэнгээрээ татсан юмуу? халаагч, салхивч ажиллахгүй байна.

Хөх бүрдний эх ХХК-ийн инженер Н.Батбаатар: үндсэнгээрээ татсан, холболт хийгдээгүй байгаа. Холболт хийгдэхээр бүгд ажиллана.

Дутуу материалууд хэзээ ирэх вэ?

Хөх бүрдний эх ХХК-ийн инженер Н.Батбаатар: Дутуу материалууд ирчихсэн байгаа. Одоо угсрагдаал болно.

Гишүүд цахилгаан хангамжийн зураг төсөл, баримт бичиг, барилга угсралтын ажилтай газар дээр нь танилцаад дараах саналуудыг өгөв.

Хот байгуулалын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн П.Мөнх-Эрдэнэ

- Дотор заслалын ажлын дутууг гүйцээх.
- 4р давхрын душнд босго нааж хийх
- Бассейн ажлуулах аюулгүй ажиллагааны зааврыг ашиглагчид өгөх
- 2,3-р давхрын душны шилэн хана/вакум цонх/нд бууруулагч наах.
- Дээврийн ус зайлуулах хоолойн амсарыг засварлах.
- Барилгын дутуу тоноглолыг үүрэг даалгавар биелэлтийг хугацаанд хийж гүйцэтгэх/хөхөгч,хаалга,сантехник,коллектор/
- Шилэн ханануудад бэхэлгээ хийх.
- Халаах системийн ажиллагааг хүн ажиллахад ойлгомжтой болгох,эсвэл т мэдргэчтэй болгох эсвэл халаагуур нэмэх

Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн М.Цэцэгсүрэн

- Коридор үйлчүүлэгчийн өрөө, 00, угаалга, душ өрөөнүүдэд бариул /ханын/ хүүхдийн бариул тоноглол гүйцээх.
- Хаалгануудад хязгаарлалт тогтоох. Давхаруудад дуугүй хөтөч нааж ашиглалтанд өгөхдөө мэргэжлийн байгууллагаас зөвөлгөө авч ашиглагч байгууллагатай зөвшилцөх
- Давхруудын хаалга бүрэн суулгаж ашиглагч байгууллагад бүрэн хүлээлгэж өгөх.
- Цэвэрлэгээг бүрэн хийж дуусгах.

Өмнөговь аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байгууллагуудын Ёл холбоо НҮТББ-ын тэргүүн И.Тунгалаг

- 00 угаагуурийн тоноглолыг сайн бат бэх суурилуулсан байх, толь хананд байруулах
- Тус барилгын тойм зургийн захирамж 1% үүрэг даалгаварын биелэлтийг хийж өгөх.
- Шатан дээр халтиргаанаас хамгаалсан наалт наасан байх
- Ханын бариул тоноглолуудыг бат бэх суурилуулах.
- Бассейны цахилгааныг онцгой анхаарах

Эрүүл ахуй, халдвар хамгаалалын хяналтын улсын ахлах байцаагч Б.Оюунсүрэн

- Хагарсан цонх солих
- Гүйдэг хаалга дээр тохируулга хийх
- 3н давхарын зүү эмчилгээ №20 төөнүүр №21 хануур самнуур №22 шал зориулалтын хулдаасаар солих
- Зоорийн давхар, 2 давхар №13 3 давхар №13 өрлөгийн зургийн дагуу ХБИ тоноглол хийх
- АЦӨ, Душ өрөөнүүдэд хаалтуудыг бүрэн хийх
- Унд ахуйн усны шинжилгээний хариуг авч улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах, цэвэрлэгээ хийсний дараа дахин дээж өгөх

- Гал тогооны хэсэг агаар сорох зонт дээр зориулалтын тос шүүгч сараалж суурилуулах
- Дутуу ажлуудыг бүрэн хийж дуусгах
- Усан бассейны ажил дуусаад ашиглах усны оролт гаралтаас дээж авч шинжилүүлэх
- Гал тогооны хэсэг, угаалгын хэсгийн плита хооронд зай завсар байна. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авахад татгалзах зүйлгүй.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ: ТӨХК-ийн ерөнхий инженер Т. Гантөмөр

- Үндсэн тэжээлийн холболт хийх.
- Цахилгааны холболтыг гүйцээх
- Хэмжих хэрэгсэлүүдийг хангагч байгууллагаар хэмжилт хийлгэж акт гаргуулах.
- ЕС болон давхарын самбаруудад хэмжилт болон тэмдэг тэмдэглэгээ ойлгомжтой хийж өгөх.
- Дата концентрамор хүлээлгэж өгөх
- Үндсэн тэжээлийн кабель шугмын татсан трассыг мэдээлэлийн санд оруулах.
- Цахилгааны гэрээг хийж өгөх.
- Нөөц эх үүсвэрийг суурилуулах
- Гадна тэжээлийг зургийн акт гаргуулах

Гүний ус ХХК-ний ерөнхий инженер С.Отгончулуун

- 2018 оны 869/2018 магадлал хийгдсэн ажлын зургаас Гадна УХАТ, дотор ЦБУ-ын угсаралт зөрүүтэй хийгдсэн байна. Зургийн дүгнэлтэнд тусгах.
- Бохир усны насос, цэвэр усны насос, усны нөөц сав, Химийн когулант, азон үүсгэгч, химийн дозлогч, хлор дозлогч болон бусад тоног төхөөрөмж ажлуулах зааварчлага эх хэлнээ бэлтгэж ашиглалтанд өгөх.
- Шугам сүлжээний гарал үүслийн гэрчилгээ, БНБД болон хуулийн заалт стандартын шаардлагыг хангаж засварлах, ШС-ний угаалт дээж авах

Архивын тасгийн дарга Ө.Учрал

- Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтийн эх хувь
- Ил далд ажлын актанд хангагч байгууллагуудын гарын үсэг зуруулах.
- Зураг төслийн магадлалын дүгнэлтийн эх хувь
- Хяналтын төсөв эх хувь
- Улаан дэвтэр хаах
- Магадлашгүй ажлын акт, тэмдэглэл, төсөв
- Барилга барихад байгуулсан 3 гэрээний эх хувь
- 2024, 12, 27 ны дотор бичиг баримт хүлээлгэн өгөх
- Бүх бичиг баримт эх хувь байх.

Өргөх байгууламжийн хяналтын улсын байцаагч Ж.Мөнх-Эрдэнэ

- Өргөн байгууламжуудын техникийн паспорт дүрмийн дагуу бүрдүүлэх
- УБ-албан шаардлагын дагуу бүрэн хийж дуусган фото зургаар баталгаажуулах
- Дотоод бүртгэлийн 100кг өргөлтийн байгууламжыг паспортжуулах

Эрүүл мэндийн газрын эдийн засагч О.Уугантуяа

- Дутуу байгаа бүх хаалгыг тоо хэмжээний дагуу нийлүүлэх, угсарч дуусгах
- Ашиглагч байгууллага бүрэн хүлээж авсаны дараа өмч бүртгэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх.
- Гадна саравч хийж гүйцэтгэх, хаягжуулалт хийж гүйцэтгэх.

- Вакум хаалтууд дээр бууруулагч, хаалганы хязгаарлалтууд хийх, хөтөч тэмдэглэлүүд хийх.
- Зураг төсөл дээрх гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх.
- Дутуу байгаа олон ажлыг хийж гүйцэтгэн, комиссын гишүүдийн нийт үүрэг даалгаварыг бүрэн хийж гүйцэтгэн ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх.

Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч Б.Наранцацрал

- Аянга зайлуулагч газардуулгыг зургийн дагуу хийх.
- Дотор усан хангамж ГК-ийн холболтыг засах, ус алдагдалыг зогсоох, туршин шалгах.
- Дулаалгын материалын галд тэсвэржилтын зэргийг ОБЕГ-ын гамшиг судлалын хүрээлэнгийн лаборторт шинжлүүлэх.
- Гадна гидрант төлөвлөгөөгүй талаар зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгана, галын байцаагчийн дүгнэлттэй танилцаагүй байна гэж үзэж байна.
- Зурагт /ДГ/ аваарын гэрэлтүүлэг төлөвлөгөөгүй зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгах.
- Дотор байнгын шатны хаалганы онгойх хэсгийг зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгах.
- Холбоо дохиололын гар мэдээлэлийг зургийн дагуу хийх.
- Дээврийн ус зайлуулах хэсгийг засварлах.
- Дээврийн агааржуулалтын /амьсгалах клапан/ битүүрсэн байна, цэвэрлэгээ хийх шаардлагатай.

Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн Өмнөговь аймгийн газрын ерөнхий инженер А.Нарантунгалаг

- Үүрэг даалгаварын дагуу ашиглалтанд авна

Даланзадгад дулаан хангамжийн газар; ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер Р. Цогтбаатар

- Үүрэг даалгаварын дагуу ашиглалтад авна

“Онч Тэнхлэг” ХХК-ны ерөнхий инженер Т.Баттулга

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бариулыг коридорт эмчилүүлэгчийн өрөөнд хийх
- АЦӨ-ний хаалт толийг хийх.
- Гадна хаяг хийх
- Усан бассейны хэсгийн ажлыг гүйцээх
- Хаалга бүрэн суулгах
- Душ болон усан эмчилгээний хэсгийн шилэн хаалганд бүрсгэр хуулга хийх
- Гадна эмчилгээний болон амрах саравчийг хийх.
- Дулааны хөшиг үүдний хэсэгт хийх
- Гал тогооны өрөөний агуулахыг бүрэн хийж дуусгах./ Хөндий шал тавиурын хана/
- Бассейны хэсгийн шалны доор хамгаалалт хийх.

Хурал даргалагч: Өгөгдсөн үүрэг даалгавар 14 хоногт амжихаар байна уу?

“Хөх бүрдний эх” ХХК-ийн барилгын инженер Ж.Отгонцэцэг

- Манай зүгээс захиалагчаас ирсэн саналыг харсан. Манай байгууллага өмнө нь хэдэн эмнэлэг улсын комиссын ашиглалтад өгч байсан. Отгончулуун байцаагчийн хэлсэн гадна дулааны хэмнэлт, урьд нь 2018 онд зурган дээр 371м гадна дулааны ажил хийгдэхээр байсан боловч тухайн барилга зарагдаад 2023 онд хажууд ирчихсэн, энэ ажлын хэмнэлт зөрүүнд барилга хөөсөн фасадтай байсныг зургийн зохиогч, захиалагчтайгаа хэлэлцэж металл фасадтай болгож өөрчилсөн. Дотор хана бүгд

эмүльс будгаар байсан. Үүнийг урьд ашиглалтад өгсөн эмнэлгүүдийн туршлагаар харахад угааж арчиж болдоггүй, нян бактер үрждэг учраас өөрийн санаачилгаар зургийн зохиогч болон захиалагчтай зөвшилцөн тосон будгаар солиод хийгдэж байгаа. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын хувьд бол 14 хоногийн хугацаанд амжуулаад пилтаны, силконы, хаалга, цонхны бариул гээд бүх ажлуудаа иж бүрнээр нь, тоо ширхэгээр нь хүлээлгэж өгнө. Ус дулааны заалтаар нь төлбөр мөнгөнийхөө асуудлыг цэгцэлж хүлээлгэж өгнө. Бичиг баримтны хувьд 4 хувь үйлдсэн байгаа. Учрал байцаагч бичиг баримт болж байна, 3-н гэрээ эх хувиараа шаардлагатай гэсэн ба түүнийг нөхөж хийгээд техникийн бичиг баримтаа бүрэн хүлээлгэж өгч байгаа. Манай хөрөнгө оруулалт дутуу байгаа. 2025 онд санхүүлжилт байгаа. Энэ онд улсын комисс ажилуулсан учир нь манай гэрээний хугацаа 2024/12/31-нд дуусаж байгаа. Гэрээ дуусгаад сунгалтын асуудал үүсэх учир яаравчилсан. Манайх 14 хоногийн хугацаандаа зураг төсөлд заагдсан бүх ажлуудаа хийнэ.

Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Н. Түвшинзаяа

- Цонх болон хаалгыг цилкондох
- Усны дээжийн шинжилгээ хийх
- Хагарч цуурсан плитануудыг наах цилкондох.
- Гадна хаяг хийх
- Ханын бариул хийх /мөн ХБ иргэдийн 00-г засварлах.
- Гал тогооны өрөөний агуулах дуусгах.
- 1ш тог баригч дутуу хийгдсэн байна.
- Зураг төсөлд рентгений өрөөнд хамгаалалт, хаалт хийгдээгүй тул ашиглалтанд авахад хүндрэл учирсан байна.
- 14 хоногт үүрэг даалгаварын биелэлт амжихгүй байна комисс дахин ажиллах саналтай байна.

Эрүүл мэндийн газрын дарга Ц.Жавзандулам

- Зоорийн давхарын ажлыг бүрэн дуусгах бассейныг технолгийн дагуу бүрэн хийх.
- Бүх өрөөний хаалгануудын резин жийргэвчийг бүрэн хийх, нөхөөс дуусгах
- АЦӨ-нүүдийн тоноглолыг бүрэн дуусгах
- Мөн АЦӨ-нд пампарс солих тавиур хийх.
- Мэдрэгчтэй угаагуур хийх газар нь хийгдээгүй
- Хагархай цонх солих, вакум хаалтыг бүрэн босгох, бэхлэх
- Шалны хөвөөг бүрэн наах
- Лифтны шитны хөвөөг засах зай завсаргүй болгох.
- Цахилгаан халаагчийг бүрэн ажиллуулах, халаалтыг жигдрүүлэх.
- Гадна талбайд сүүдрэвч, элс давстай талбайг хийж өгөх.
- Гадна хаяг хийж байруулж өгөх
- Гадна гэрэлтүүлэгийг хийх.
- Хашааны тэмдэглэгээ, тоноглол бүрэн дуусгах.
- Гал тогооны душны өрөөнд босго хийх
- Гадна аваарын шатны ажлыг бүрэн хийж дуусгах
- Энэхүү барилгын бичиг баримтийг ашиглагч байгууллагад /ЭМТ/хувийг өгөх
- Тог ус дулааны тооцоог комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлсэний дараа дуусгаж ашиглалтад өгөх

- Дулааны улиралд гадна фасадны цэвэрлэгээг хийж өгөх.
- Агааржуулалтын тоноглолыг бүрэн хийж дуусгах

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Хяналт, шалгалтын хэлтсийн дарга Л.Эрдэнэ

- Комиссын гишүүдээс өгөгдсөн үүрэг даалгаврыг бүрэн хийж гүйцэтгэх.
- Зоорийн давхарын бассейны битүүмжлэлийг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэж, тоноглолыг бүрэн хийж, туршилт хийж гүйцэтгэх
- Хаалгануудыг бүрэн суурилуулж амалгааг засварлах.
- Заалны хэсгийн таазны хэсгийг заслал болон сүлжээний утасны гаргалгааг гаргахдаа гипсэн хаалтыг цоолсон байгааг засах.
- Дээврийн ус хаялагын трапны хэсгийн торлолтыг зохистой байдлаар шийдвэрлэх.
- Дээврийн У-2 тэнхлэг дагуу Х2,Х6 тэнхлэгт байрлах агааржуулалт мөн Х2 тэнхлэгт байрлах агааржуулалтын хоолойн малгайвчуудыг хийх.
- Эвдэрсэн малгайвч төмөр засах, агааржуулалтын хоолойруу наасан хар цаасан хучлагыг ам дарах,урагдсан хар цаасыг засварлах.
- Дотор гадна силконы ажлыг бүрэн хийж гүйцээх.
- Дээврийн Х2, Х6 тэнхлэг дагуу металл хийцээр парapedны малгай хийж өгөх.
- Барилгын тухай хуулийн 14р зүйлийн 14.3, 14.6 дахь заалтын хугацаанд гүйцэтгэлээс шалтгаалсан гологдол дутагдал үүссэн тохиолдолд тухай бүр засварлах.
- Дутуу ажлуудад жагсаалт гаргаж дулааны улиралд хийж гүйцэтгэх ажлыг захиалагч ашиглагч байгууллагад албан бичгээр хүргүүлэх.
- Зургаас өөрчлөгдсөн хийцлэлүүдийг зураг зохиогчийн нэгдсэн дүгнэлтэнд бүрэн тусгах.
- Гүйцэтгэлийн зураг хийлгэж хот байгуулалтын мэдээлэлийн санд бүртгүүлэх.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг хуулийн хугацаандаа хийж гүйцэтгээд амжсан тохиолдолд тухайн барилга байгууламжийг байнгын ашиглалтад шилжүүлб. Амжаагүй тохиолдолд ашиглалтад оруулах журмын дагуу дахиж улсын комисс ажиллана.

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 “туршилт тохируулгын хугацаа 1 жил” болон 14.6-д “хувийн ашиглах ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил” гэж зааснаар энэ хугацаанд гүйцэтгэлтэй холбоотой гарсан гомдол, саналыг авч ажиллана.

Танилцсан:

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Хяналт, шалгалтын хэлтсийн дарга



/Л.Эрдэнэ/

Тэмдэглэл хөтөлсөн:

Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

.....

/Н.Түвшинзаяа/